



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.18 № 03/2163

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зарласан НХААГ/20240102626 дугаартай "Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Захиалагчийн хариу
1	Манай компани нь Диализын аппарат, усны төхөөрөмжийг улс даяар нийлүүлж байсан туршлагатай бөгөөд дээрх тендерийн багцад Диализын аппарат, усны төхөөрөмж дээр зөвхөн Mindray фирмийн аппарат хэрэгслүүдийг нийлүүлээд багцалсан байна. -Mindray фирм нь Монгол улсад хоёрхон төлөөлөгчтэй байгаа нь өрсөлдөх боломжийг олгохгүй байна. -Иймд дээрх багцыг салгаж өгч өрсөлдөх боломжоор хангаж өгнө үү.	-Захиалагчийн хяналт тавих байгууллагаас шинэчлэн баталсан техникийн тодорхойлолтыг хавсралтаар хүргүүлэв. Гемодиализын эмчилгээний аппарат, Гемодиализын эмчилгээний аппарат ус цэвэршүүлэх систем (RO)-ийн үзүүлэлтийг шинэчилсэн болно. Тус нээлттэй тендер шалгаруулалтыг 3 багцад хувааж өөрчилсөн болно. Та бүхэн шинэчилсэн тендер шалгаруулалтын бичигтэй Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр орж танилцана уу.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт оруулж байна.

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1, 26.2 дахь хэсэг. -"Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минут; -Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минут" гэснийг;	-"Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 00 минут; -Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 30 минут" гэж өөрчлөв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд

нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 17 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар  
Удирдлага  
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Даваадорж Батцэцэг  
2024.11.18 16:28